

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Далхаасүрэн	Дугаар	L161
Оршин суугаа аймаг	Сэлэнгэ	Оршин суугаа сум	Ерөө
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дарь эхийн хурал	Сүм хийдийн дугаар	СЭЕР 037
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 21	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Дарь эхийн хурал

Асуулт:-Далхаасүрэн гуай бидэнд тус сумын нутагт байсан Дарь эхийн хурлын тухай ярьж өгнө үү?

Хариулт:-Би анх энэ Сангийн аж ахуй байгуулахад 1953 онд ирсэн. Ирснээсээ хойш энд 26-тай ирээд одоо 83 хүрээд явж байна. Би энэ орон нутгийн түүх, дурсгалын зүйлс, янз бүрийн юм сонирхдог ийм хүн байгаа юм. Ийм учраас би Нийслэл хүрээ, Орхоны хөндийгөөс атан тэмээ, амбан шараа аахилуулсан нүүж ирсэн тухайгаас эхлээд энд байгаа ганц нэг дуган сүмүүдийн тухай товч мэддэг юм. Мэддэг зүйлээ та нөхдөд тус болгож нэмэрлэе гэсэн юм.

Дарь эхийн хийдийн сүм гэдэг бол энэ **Буургачин** уулын маань цаад дор байдаг юм. Одоо тэнд дуганы суурь, тэнд толгойтой, толгойгүй бурхан байдаг. Анх байгуулахдаа Дарь эхийн хийдийн гол шүтээн болсон ногоон дарь эхийг бадарчлах маягаар энэ нутгийн өвгөн лам явж, тэндээс Төвдөөс өөрөө хүзүүндээ зүүж авчирсан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байгаа юм. Ингээд Дарь эхийн хийдийг байгуулаад ингээд ажиллаж байсан.Тэгтэл Ардын хувьсгал мандаж гамин, **цагааныхантай** байлдаж байх үеэр Дарь эхийн хийд нэрвэгдэж, тэндхийн лам нар алагдах нь алагдаад, **зугатаах нь зугатаагаад** ингээд тэрний дараа бурхан, судруудыг нь хэмхчээд нураагаад ингээд хаясан. Сүүлд нь Дарь эхийн хийдийн гол шүтээн болсон Зандан Дарь эхийг.

Асуулт:-Зандан модоор хийсэн?

Хариулт:-Тийм. Зандан модоор хийсэн Дарь эхийг авчирсан хүн маань өөрөө биеэрээ аваад тэрнийгээ олж аваад тэр бутарсан бурхан дотроос тэгээд Баянголын рашааны арын өндөр **Морьтонгийн** агуйд нуусан гэдэг юм. Тэр бол одоо хүртэл ямар ч хүн олж авч чадаагүй, агуй нь олдохгүй байгаа ийм газар. Өөрсдөө очоод хийхдээ хийх гэсэн чинь хүрч болохгүй тэрэгнийхээ арлыг авч шат тавьж байж гарч **бурханаа** тэнд байрлуулсан гэж байгаа юм, одоо бол олдохгүй байгаа юм. Ингээд Дарь эхийн хийд гэдэг бол тэр үедээ нэлээд **цууд** гарсан, шүтэгдсэн, Сэлэнгэ нутгийн ард **түмнүүдээс** ирдэг, мөргөл хийдэг, **Майдар** цам үздэг ийм шашны төв байсан байгаа юм.

Асуулт:-Хамба лам нь хэн гэдэг хүн байсан бол?

Хариулт:-Хамба лам нь Доржпалам гэж хүн байсан байгаа юм. Ингээд энэ хийдийг устсанаас хойш намайг ирэхэд дуганы суурь, толгойтой, толгойгүй бурхан их байсан. Ийм л газар байгаа юм. Энэ бол мөн хурал хурдаг бүх юмыг хийдэг шашны хийдэг юмнуудыг. 100 гаран ламтай ийм хийд байсан. Тэрний ихэнх нь баригдаад алагдаад зарим нь алагдаагүй тийм улсууд нь Ерөөгийн лам нарын хорих гэж байсан тэнд хоригдож байгаад тавигдсан.

Асуулт:-Лам нарын хорих гэж хаана байсан юм бэ?

Хариулт:-Яг л энэ дээр байсан юм.

Асуулт:- Дандаа лам нарыг авчирч хорьдог байсан юмуу?

Хариулт:-Тийм, дандаа лам нарыг авчирч хорьдог байсан. Ямар сайндаа ажил хийхгүй байна та нар тамхиа татаж хуруундаа хавчуулж суугаад гээд загнаад нэг ламын **хормойгий** нь бариулаад түүгээд ир гээд лам нарыг жагсааж байгаад хөөргийг нь хураагаад **Буургачинд** булсан гэдэг юм. Ийм л учиртай хорих байсан. 53 онд Атрын сангийн аж ахуй байгуулахад Говь-Алтайгаас 4 машин, Ховдоос 4 машин, илгээлтийн малчид авчраад хоригдлуудаас мал хүлээж аваад ингээд энэ Сангийн аж ахуй анх бий болсон юм. Ингээд байгуулахад нь би энд ирсэн.

Асуулт:-Тэр хорихыг хэдэн онд байгуулсан юм бэ? лам нарын хорихыг.

Хариулт:-Тэр лам нар барьж байхад л байхгүй юу. 30 хэдэн онд л. Атрын сангийн аж ахуй байж байгаад, сүүлд нь буцаж сүм болоод байж байгаа, Ерөө сүм гээд.

Асуулт:-Дарь эхийн хурлын цам, **Майдар** гардаг байсан тухай хэлж өгөхгүй юу?

Хариулт:-Тийм юм тоглодог байсан. Тэр чинь манайхнаар бол бас л лам нарын урлаг л даа.

Асуулт:-Хэдэн сард гардаг байсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Хавар, намарт л гардаг байсан байх гэж бодож байна. Би ер нь хотод байхад хавар, намар хоёр үзэж байсан санагдаж байна. Би хотод сууж байсан хүн. Тэгэхэд лам нар байсан. Тэр үед би Төвд ном заалгаж байсан, уншдаг, бичдэг болсон. Тэгээд дараа нь лам нар баригдахаар босоо монгол ном заалгасан. Тэрнийг уншдаг, бичдэг болсон. Дараа нь латин заалгасан. Уншдаг, бичдэг болсон. Тэгээд сүүлд нь кирилл болсон, кириллээ уншдаг бичдэг болсон. Намайг сургуульд ороход одоог бодвол шал өөр байлаа л даа.

Асуулт:-Цамынхаа багийг өөрсдөө хийдэг байсан юмуу?

Хариулт:-Тийм. Цэрэгт яваад ирэхэд чинь одоотой адилгүй, Хадны ламын дацан гэж байсан.

Асуулт:-Тэр нь хаана байсан юм бол?

Хариулт:-Тэр одоо та нар хойд замаараа явах юм бол яг шувтрах өндөр хамар дээгүүр гардаг юм, сэтэлчихсэн хамар дээгүүр.**Тэрний** наад талд хадан хясаанд байсан гэж ярьдаг юм, хуучцуул.

Асуулт:-Тэнд нэг л лам бясалгал хийдэг?

Хариулт:-Нэг л лам байсан. Наад юунд мөн адилхан нэг лам, нэг дацантай, тэр голдоо. Тэрний суурь гэж нэг дөрвөлжин газар байдаг юм.

Асуулт:-Тэнд ямархуу хэд орчим ламтай байсан юм бол?

Хариулт:-Тэр 2, 3 ламтай байсан.

Асуулт:-Цөөхөн.

Хариулт:-Тийм цөөхөн ламтай. Жинхэнэ Дарь эхийн хийд бол 100 гаруй ламтай байсан гэж тэр үед байсан улсууд надад ярьж байсан юм. Би орон нутгаа амьдарч байгаагийн хувьд судалдаг.

Асуулт:-Дарь эхийн хийдийг юугаар барьсан байсан юм бол?

Хариулт:-Модоор.

Асуулт:-Дараа нь яасан юм бол?

Хариулт:-Дараа нь гамингийн үед шатаагаад хаяхгүй юу?

Асуулт:-Одоо бол юу ч байхгүй гэсэн үг үү?

Хариулт:-Одоо бол суурь нь байна. Толгойтой, толгойгүй шавар **бурханууд** байна.

Асуулт:-Дарь эхийн хийд дотроо хэр олон дацантай байсан юм бол, Зурхай, **Чойр гээд?**

Хариулт:-Дотроо 2, 3 жижиг суурь байдаг юм. Тэрнийг нь би юманд явчихгүй бол заагаад өгье. Тэгэхдээ та нар нутгийн Хүрлээ гэж нэг өвгөн байгаа. Тэр өвгөнийг аваад явах юм бол Хүрлээ гуай бүр Дарь эхийн хийдийг Далангийн хийдтэй нь хамт заачих байх гэж би бодож байна.

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Уялгын дуган

Асуулт:-Та бидэнд Уялгын дуганы тухай ярьж өгнө үү?

Хариулт:-Би тэр нутагт нутаглаж байсан. **Тэгээд ухаан** ороход л тэр дуган буучихсан байдаг юм. Ард талд Буурал овоо гэж том овоо байдаг юм. Тэгээд тэр Буурал овооны урд хормойд замын доод талд тэр дуганы суурь байсан. Би тэрнийг сайн мэднэ.

Асуулт:-Хэд орчим оны үед юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Би уг нь 37 оны хүн л дээ.

Асуулт:-42, 43 оны үед гэсэн үг үү?

Хариулт:-Тийм л юм шиг байна. Би 45 онд 9 настай сургуульд орж байсан юм.

Асуулт:-Хэд орчим ламтай дуган байсан юм бол?

Хариулт:-Уялгын дуган их том дуган байсан юм гэнэ лээ. Миний ухаан ороход тэр зүгээр суурь нь л байдаг юм.

Дуган байхыг мэдэхгүй. **Суурийг нь** сайн мэднэ. Замын урд талд овооны урд талд байсан юм.

Асуулт:-Уялгын дуганы лам нар ямар овоог тахидаг байсан юм бол?

Хариулт:-Буурал овоо гэдгийг тахидаг байсан.

Асуулт:-Зун тахидаг байсан юм болов уу?

Хариулт:-Зун тахидаг байсан биз дээ. Сүүлийн үед миний ухаан орсноос хойш тэр дуган ч буучихсан байсан.

Хэдийд нь буусан юм. Хэлмэгдлийн үеэр л буусан юм байлгүй дээ. 38 онд хамаг улсуудыг чинь бүгдийг нь хэлмэгдэлд аваад явчихсан л байхгүй юу. Эрэгтэй хүн тэр хавьд нэг ч хүн байхгүй. Бүгдийг нь хэлмэгдлээр аваад явчихсан байдаг юм. Дандаа эхнэрүүд нь үлдчихсэн, мал хөрөнгийг нь хураагаад аваад явчихсан. Тэгээд дандаа эмэгтэйчүүд үлддэг юм шиг байгаа юм л даа.

Асуулт:-Уялгын дуганыг модоор барьсан байсан уу?

Хариулт:-Мод л байсан юм шиг байгаа юм, модон суурь л байдаг байсан.

Асуулт:-Хэр том суурь байсан юм бол?

Хариулт:-Нэлээн томоохон суурь байсан даа. Замын урд талд би хүүхэд байхад **тэрүүгээр** тугал, бяруугаа хариулж явахад жимс их ургадаг газар байсан. Овооны урд талд байдаг байсан байлгүй. Тэр овоо их том овоо. Тэр Буурал овоо гэдэг чинь.

Асуулт:-Тэр хийдэд тэд орчим лам хурал ном хүрж байсан гэж дуулсан юм байна уу?

Хариулт:-Тэрнийг би мэдэхгүй. Манай ээж байхдаа л мэдэж байсан байх л даа. Манай ээж саяхан 1990 онд 84 хүрч нас барсан юм.

Асуулт:-Уялгын хийдэд буриад голдуу хүмүүс хурал ном хүрж байсан уу?

Хариулт:- Дандаа буриадууд л байсан юм шиг байна лээ. Тэр нутагт чинь дан буриадууд байсан байхгүй юу, энэ хавиар дандаа буриадууд байсан юм.

Асуулт:- Тэр хэлмэгдлийн дараа бурхан тахилыг нь яасан юм бол?

Хариулт:- Тэрнийг мэдэхгүй юмаа, бурхан тахилыг нь тэр овоонд өргөсөн юмуу, яасан юм тэнийг би мэдэхгүй.

Асуулт:-Сумын төвийн ойролцоо Хүдрийн дуган гэж байсан гэсэн тэрнийг та мэдэх үү?

Хариулт:-Хүдрийн дуган гэж голын баруун талд байдаг л даа, суурь нь. Жаахан овоо байдаг юм.

Асуулт:-Тэр дуганы талаар мэдэх үү?

Хариулт:-Мэдэхгүй.Тэрнийг ерөөсөө мэдэхгүй. Тэр дуган чулуун суурьтай юм билээ. Тэрнийг бас л цаашаа наашаа явж байхдаа. Жижигхэн шовгор уул байдаг байхгүй юу.

Асуулт:-Хүдрийн дуганы тухай өөр мэдэх хүн байна уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Энд нэг настай хүн байсан, өнөөдөр ийшээ нүүгээд явчихсан.